

ДЭД СТАНЦЫН ӨРГӨТГӨЛИЙН БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2020 оны 05 дугаар
сарын 06 -ний өдөр

№ ТХК-АЖТ/2020/013

Улаанбаатар хот

Энэхүү ПК0+00-ПК416+160 хооронд баригдах тэжээл үүсгүүр талын 3-р багцын Зүүнбаян дэд станцын 35 кВ хүчдэлийн өргөтгөлийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ /Цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас: Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ыг төлөөлж Замын дарга Д.Жигжиднямаа (цаашид "Захиалагч" гэх),

Нөгөө талаас: Улсын бүртгэлийн 2710001002, Регистрийн 2008904 дугаартай "БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал албан тушаалтай Н.ТАВИНБЭХ (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нар хүсэл, зориг, ашиг сонирхлоо бүрэн илэрхийлж Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйл заалтыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг тал харилцан хүлээн зөвшөөрөв.

НЭГ.НИЙТЛЭЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээний зорилго Дэд ажлын хэсгийн 2020 оны 4 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн ПК0+00-ПК416+160 хооронд баригдах тэжээл үүсгүүр талын 3-р багцын Зүүнбаян дэд станцын 35 кВ хүчдэлийн өргөтгөлийн барилгын ажлыг батлагдсан зургийн дагуу гэрээт ажлын дүнд багтаан ажлыг гүйцэтгэх энэхүү гэрээгээр харилцан тохиролцсон ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахтай холбогдсон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн хүлээх үүрэг, эдлэх эрх болон хариуцлагыг тогтооход оршино.

1.2 Гэрээт ажил: Гэрээний хугацаанд энэхүү гэрээний 1-д заасан хэсгээр хавсралт 1-д заасан ажлыг иж бүрэн хийж гүйцэтгэнэ.

1.3 Гэрээний нийт үнийн дүн: **1,268,766,514 /Нэг тэрбум хоёр зуун жаран найман сая долоон зуун жаран зураан мянга таван зуун арван дөрвөн/ төгрөг** байна. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татвар, хураамжуудыг ГЕН-ийн 49 дэх хэсэгт заасны дагуу Гүйцэтгэгч нь хуульд заасан хэмжээгээр өөрөө хариуцан барагдуулна.

1.4 Гэрээний үнийн задаргааг Хавсралт №4-д заасан болно. Энэ үнэнд тоног төхөөрөмж, холбох хэрэгсэл, тэдгээрийг суурилуулах болон материалын, ажлын хөлс, тээврийн зардал багтсан бөгөөд НӨАТ багтсан болно.

1.5 Дор дурдсан гэрээ, баримт бичиг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд эдгээрийн хамт энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр байна. Үнд:

1.5.1 Гэрээ

1.5.2 Гэрээний ерөнхий нөхцөлүүд

1.5.3 Гэрээний тусгай нөхцөлүүд

1.5.4 Хавсралт 1 Ажлын зураг (Ажлын даалгавар)

1.5.5 Хавсралт 2 Техникийн шаардлага /техникийн тодорхойлолт/

1.5.6 Хавсралт 3 Ажлын төсөв /зардлын задаргаа/

1.5.7 Хавсралт 4 Гүйцэтгэл тооцох хуваарь

1.5.8 Хавсралт 5 Үе шатны ажлын хуваарь

1.5.9 Хавсралт 6 Ажлын график төлөвлөгөө

1.5.10 Хавсралт 7 Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн жагсаалт, ажиллах хүчний мэдээлэл,

1.5.11 Хавсралт 8 Үе шатны ажлын тайлан гаргах хуваарь

1.5.12 Хавсралт 9 Гэрээ дуусгавар болсны дараа хүлээлгэн өгөх бичиг баримтын жагсаалт

1.5.13 Хавсралт 10 Гэрээг гүйцэтгэх бараа, материал, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлын шаардлага, /Ажил эхлэхээс өмнө тухай бүрд нь Захиалагчид гарган өгч зөвшөөрөл авна/

1.5.14 Холбогдох бусад бичиг баримтууд /Гүйцэтгэгч компанийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, итгэмжлэл, гэрчилгээ, гүйцэтгэх захирал эсвэл эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэх г.м /нотариатаар баталгаажуулсан байна/.

ХОЁР. НЭР ТОМЬЁО

Энэхүү Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1 "Гэрээ" гэж Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан энэхүү ажил гүйцэтгэх Гэрээг,

2.2 "Захиалагч" гэж "УБТЗ" ХНН

2.4 "Гүйцэтгэгч" гэж "БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-ийг;

2.5 "Гэрээний үнэн" гэж Үйлчилгээг гүйцэтгэхэд зориулан Гүйцэтгэгч энэхүү Гэрээний 1.1-д заасны дагуу баталсан төсвийн үнийн дүнг;

2.6 "Гүйцэтгэх ажил" гэж Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх энэхүү Гэрээний Хавсралт 1-д тодорхойлсон ажлыг;

2.7 "Ажил эхлэх өдөр" гэж Гүйцэтгэгчийн ажил эхлүүлэх өдрийг тус тус хэлнэ. Энэ өдрийг ГТН-ийн 1.1 дүгээр зүйлд заах бөгөөд ажлын талбайг эзэмших өдөртэй давхцаагүй байж болно.

2.8 "ГЕН" гэх товчилсон үгийг Гэрээний ерөнхий нөхцөл гэж ойлгоно,

2.9 "ГН" гэх товчилсон үгийг Гэрээний тусгай нөхцөл гэж ойлгоно,

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээний хавсралт 1-д заасан ажлыг үр дүнтэй, чанарын шаардлагын дагуу, хугацаандаа гүйцэтгэхэд хяналт тавих үүрэг хүлээнэ.

3.2 Захиалагч нь Гүйцэтгэгчийн хариуцсан инженерээс ирүүлсэн гүйцэтгэлийн үнэн зөв, алдаагүй байдалд хяналт тавьж баталгаажуулна.

3.3 Ажлын хэрэгжилт, ажлын явц, тайлан мэдээтэй чөлөөтэй танилцах, газар дээр нь үнэлгээ шалгалт хийх, шаардлага тавих эрхтэй.

3.4 Захиалагчийн инженерүүд нь зөвхөн гүйцэтгэсэн ажлын хяналтын санхүүжилтийг "МТЗ" ТӨХК хариуцна.

3.5 Гүйцэтгэгч нь санхүүжилтийг зориулалтын бусад ашиглах, төслийн хэрэгжилт, ажлын гүйцэтгэлийн явцад зөрчил гаргасан тохиолдолд гүйцэтгэлийг баталгаажуулахгүй, улмаар гэрээг цуцлах эрхтэй.

3.6 Гэрээний үнийн дүнд гэрээний хавсралт 2 заасан техникийн шаардлага, ажлын даалгаварт заасан бүх ажлыг бүрэн хийж гүйцэтгэх бөгөөд илүү хийсэн ажилд төлбөр нэмж төлөхгүй болон гарсан аливаа зардалд Захиалагч хариуцлага хүлээхгүй болно.

3.7 Ажлын явцад Захиалагчийн зүгээс ажлын зураг, төсөлд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд үүнтэй холбоотой ямар нэг нэмэгдэл зардлыг Гүйцэтгэгчид төлөхгүй болно.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

4.1 Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болох хавсралт 1-д заасан ажлыг үр дүнтэй, батлагдсан зураг төслийн дагуу техникийн болон чанар, стандартын шаардлага ханган гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

4.2 Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт 1-д тодорхойлсон зураг төсөлд заасан ажлыг хийж гүйцэтгэх үүрэгтэй.

4.3 Гүйцэтгэгч нь ГТН-ийн 1.1 дүгээр зүйлд Захиалагчаас шаардаж буй хавсралт 1-д заасан ажил үүргийг хавсралт 2-т заасан техникийн шаардлагын дагуу гэрээнд заасан хугацааны дотор хийж гүйцэтгэх мэргэжлийн дадлага туршлагатай инженер, техникийн болон бусад ажилтнууд болон тоног төхөөрөмж, техникийн эх үүсвэртэй байна. Гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу ажлыг хийж гүйцэтгэхийг энэхүү гэрээгээр хүлээн зөвшөөрсөн байна.

4.4 Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан нөхцөл, болзолд нийцүүлэн хавсралт 1-д заасан ажлыг зохих ёсоор гүйцэтгэж, зөрчил доголдол гаргасан үед түүнийг яаралтай засах, арилгах үүргийг хүлээнэ.

4.5 Ажлын явцтай холбоотой мэдээ тайланг Захиалагчид гэрээний хавсралт 8-д заасан хугацааны дагуу тухай бүр хүргүүлэх үүрэгтэй.

4.6 Санхүүжилт авахтай холбогдуулан хүргүүлсэн аливаа мэдээлэл, тайлан, нэхэмжлэхийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

4.8 Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан нөхцөлийн дагуу дурдагдсан ажлыг гүйцэтгэх явц болон чанарын баталгаат хугацаанд гарсан эвдрэл гэмтлийг өөрийн зардлаар засах /солих/ үүрэг хүлээнэ.

4.9 ГТН-д өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь гэрээ байгуулахаас өмнө гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бүхий л шаардлагатай баримт бичиг, зөвшөөрөл, гэрчилгээг холбогдох эрх бүхий байгууллагаас авсан байх үүрэгтэй.

4.10 Дараах тохиолдолд Гүйцэтгэгч Захиалагчид санал гаргаж болно. Үүнд: Гүйцэтгэх ажил үүргийг гэрээнд заасан хугацаанаас өмнө дуусгахтай холбоотой, Гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг багасгахтай холбоотой, Гүйцэтгэх ажил үйлчилгээний үр дүнг сайжруулах тухай, ашигтай санал зэрэг болно.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс үүдэн гарах хариуцлагыг буруутай тал нь хариуцна.

ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1 Энэхүү Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан албаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.2 Хэрэв тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд талууд уг маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

7.1 Давагдашгүй хүчин зүйлийн талаар ГЕН-ийн 28 дугаар зүйлд зааснаар ойлгоно.

НАЙМ. БУСАД

8.1 Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Гэрээний Хавсралт, нэмэлт Гэрээнүүд нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

8.2 Талууд ГЕН-ийн 4 дэх хэсэг заасны дагуу Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэх бөгөөд эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр гэж тооцогдох ба энэхүү Гэрээний салшгүй хэсэг байна.

8.3 Гэрээнд заасан үүрэг биелэгдсэнээр ГЕН-ийн 52, 53 дахь хэсэг заасны дагуу гэрээ дуусгавар болно.

8.4 Гэрээг 2 эх хувь үйлдэх ба хууль зүйн хувьд адил хүчин төгөлдөр байна.

8.5 Гэрээтэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, албан бичгийг дараах хаягаар хүргүүлнэ. Хаяг өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухай бусад Талууддаа мэдэгдэх нь Талуудын үүрэг ба ийнхүү мэдээлээгүйгээс үүсэх хариуцлагыг тэдгээрийн хүргүүлсэн Тал хариуцахгүй болно.

8.6 Талууд гэрээний бүх заалттай бүрэн танилцаж маргаангүй болохыг нотолж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"УБТЗ" ХНБ-ийн дарга



Д. ИГЖИДНЯМАА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-н гүйцэтгэх захирал



Н. ТАВИНБЭХИ

ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

№	Санхүүжилтийн			Хугацаа	Ажлын	
	Үе шат	Мөнгөн дүнгийн эзлэх /%/	Мөнгөн дүн /төгрөг/		Эзлэх хувь /%/	Хийгдэх ажилбарууд
1	I	30	380,629,954	VI/20	30	Урьдчилгаа /Үе шатны ажлын хуваарийн ажилбар 1-ийг эхлүүлнэ/
2	II	30	380,629,954	VI/30	40	Үе шатны ажлын хуваарийн ажилбар 2,3,4
3	III	35	444,068,280	VII/30	30	Үе шатны ажлын хуваарийн ажилбар 5,6,7,8
4	Чанарын Баталгаат хугацаа	5	63,438,326		100	Ажилбарууд 100% хийгдсэн байна. Улсын комисс хүлээн авсны дараа гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэж үзэн Гүйцэтгэгч, Захиалагч гэрээ дүгнэсэн акт үйлдэж албан ёсоор баталгаажуулсан өдрөөс хойш чанарын баталгаат хугацаа дууссаны дараа олгог

Жич: * Тухайн гүйцэтгэл тус бүрээс чанарын баталгаа болгож 5% дуусгана.

** Гэрээний нийт төлбөр болох 1,268,766,514 төгрөгөөс уг хавсралтад заасны дагуу Захиалагч актаар ажлыг хүлээн аваад урьдчилгаа төлбөр, ажлын гүйцэтгэлийн баталгаа болгож чанарын баталгаат хугацааны төлбөр болох 5%, магадлашгүй ажлын зардлыг, гүйцэтгэлээр олгосон санхүүжилтийн төлбөрүүдийг тус тус суутган авч үлдэгдэл төлбөрийг ажил дууссаны дараа Захиалагч Гүйцэтгэгчээс ажлыг актаар хүлээн аваад тооцсон дагуу Санхүүжүүлэгч төлнө.

*** Санхүүжилтийн хугацаанд нь төлөхтэй холбоотой эцсийн хариуцлагыг Санхүүжүүлэгч хариуцна.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГУЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"УБТЗ" ХЧ-ийн дарга



Д.ЖИГЖИДНЯМАА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СЛЖЭЭ" ТӨХК-н гүйцэтгэх захирал



Н.ТАВИНБЭХ